*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын*
*акаде.мийн 821 дүгзэр дамжааны суралцагч,*
*хошууч Ц. Мягмардорж*

# МОНГОЛ УЛСЫН ХИЛ ОРЧМЫН ОРОН ЗАЙД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ АЮУЛ ЗАНАЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

***Хураангуй.*** *Цэргийн албаны аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээг хүч хэрэгсэл, цэргийн албан хаагчдын эрүүл мэнд хохирох, техникийн осол гарах болон хурээлэн буй орчинд хортой нөлөөлөл учирч болзошгүй аюулыг тодорхой магадлалтайгаар зайлуулах нөхцөлийг бурдуулж, хангах үйл ажиллагаа гэж ойлгоно.*

***Тулхүүр*** *үг. Аюул, аюулгүй байдал, болзошгүй аюул, эрсдэлийн удирдлага, хил орчмын орон зай.*

Хил орчмын орон зай *(хил орч.иын нутаг дэвсгэр)* дахь Монгол Улсын аюулгүй байдал гэдэгт хил орчмын нутаг дэвсгэр үндэсний эрх ашиг, аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол *(улс төр, нийгэм, эдийн засаг, цэрэг, шинжлэх ухаан, технологи, соёл, мэдээлэл, экологийн гэх)* хангагдсан байх цогц асуудлыг хамруулан ойлгож болно.

Хил хязгаарын аюулгүй байдлыг хангахын тулд хил орчмын орон зайд бий болсон нөхцөл байдалд нарийвчлан дүн шинжилгээ хийх, үйл явцын чиг хандлагыг урьдчилан тооцох хэрэгтэй. Мөн тодорхой нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, чиг хандлагыг урьдчилан таамаглах аргачлалын гол шалгуур бол учирч болох аюул заналхийллийг илрүүлэн тэдгээрийг ихээс нь бага хүртэл жагсаан системчлэх явдал юм.

Хил орчмын орон зайд улсын аюулгүй байдалд учирч буй аюул заналыг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, түүнийг таамаглах нь нэн хариуцлагатай үйл хэрэг бөгөөд доорхи агуулгаар илэрхийлэгдэнэ.

- Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг хамгаалах;
- Хөрш улсын нутагт гарч болзошгүй орон нутгийн чанартай дайн, зэвсэгт мөргөлдөөнөөс сэрэмжлэх, өрнөлтийг гярхай ашиглах;
- Хил орчмын нутаг дэвсгэрт Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхлыг хангах;
- Улс төр, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах;
- Төрийн байгуулалтын тогтвортой байдлыг хангах, улс орноо зөв удирдах;
- Үр нөлөөтэй дотоод, гадаад бодлогыг хэрэгжүүлэх, олон улсын харилцааг хөгжүүлэх, нэр хүндээ бататгах;

- Учрах аюулыг сэрэмжлэн зайлуулахын тулд хөрш орнуудтай хамтран ажиллах, байр сууриа хадгалан бататгах зэрэг болно.

Хил орчмын орон зайд Монгол Улсын төрийн эрх ашигт учрах гол аюул занал нь:

1. Хөрш улсын зүгээс хөндөж болзошгүй нутаг дэвсгэрийн маргаан;
2. Хорлон сүйтгэх ажиллагаа;
3. Салан тусгаарлах үзэл, шашны мөргөлдөөн;
4. Хөрш зэргэлдээх орны эдийн засаг, хүн ам зүйн хүрээний тэлэлт;
5. Үндэсний баялгийг хулгайлах, хил давуулан арилжих;
6. Стратегийн чанартай түүхий эд бүтээгдэхүүнийг хил нэвтрүүлэх ажиллагаа;
7. Хүн амын амьжиргааны түвшин буурснаар үүсэх шилжилт хөдөлгөөн;
8. Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, алан хядах ажиллагаа;
9. Улсын хилийн ойролцоо гарах бүс нутгийг хамарсан үймээн, самуун, эмх замбараагүй байдал, зэвсэгт мөргөлдөөн;
10. Осол сүйрэл, байгалийн гамшиг, хил дамнасан хүрээлэн буй байгаль орчны бохирдол зэрэг юм.

Төрийн эрх ашиг бол бие хүн, нийгмийн амин чухал эрх ашгийн илэрхийлэл мөн. Энэхүү эрх ашиг хилийн орон зайд бүрэн хэмжээгээр илрэн гарч төрийн хилийн бодлогыг төлөвшүүлэх үндэс болж байна. Хилийн орон зайд дээрх аюул заналхийлэл илрэн гарах нь төрийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэх дохио болж байгаа юм.

Бий болсон аюулд дүн шинжилгээ хийж нэгтгэн дүгнэхийн тулд юуны өмнө олдсон мэдээлэлд боловсруулалт хийж, нийгмийн амьдралын хүрээ бүрт гарч буй зөрчилд задлан шинжилгээ, төрийн эрх ашигт учрах аюулыг илрүүлэх нь чухал билээ.

Аливаа аюул тодорхой ашиг сонирхолтой холбоотой байдаг бөгөөд түүнийг саармагжуулахын тулд аюул заналхийлэл бүрийн үүсч болох магадлалыг судалж мэдэх шаардлагатай. Хил орчмын орон зайд гарч болох аюул заналхийлэл тэдгээрээс урьдчилан сэргийлэх нь түүнд тохирсон улсын хилийг хамгаалах тэнцвэржүүлсэн систем, тогголцоо буюу одоо боловсруулж буй бүсчилсэн хамгаалалтын тогтолцоог бий болгох, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн цогц, шат дараалсан арга хэмжээ авахыг шаардаж байна.

*Цэргиин албаны аюулгуй байдал* гэдэг нь аюулын хор уршгийг тодорхой магадлалтайгаар гаргуулахгүй байх нөхцөл байдал юм.

*Цэргийн албаны аюулгүй байдлын тогтолцоо* гэдгийг цэргийн албаны аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээ, хүч хэрэгсэл, түүнчлэн хууль эрх зүйн цогц буюу өөрөөр хэлбэл цэргийн албан хаагчдын эрүүл мэнд хохирох, техникийн осол гарах болон хүрээлэн буй орчинд хортой нөлөөлөл учирч болзошгүй аюулыг тодорхой магадлалтайгаар зайлуулах нөхцлийг бүрдүүлж. хангах ажиллагаа гэж ойлгож болно.

Цэргийн аюулгүй байдлын орчинг бүрдүүлэх дэд тогтолцоонд:

- Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах талаар төрийн бодлогыг боловсруулж, энэ асуудлаар хууль эрхийн болон арга зүйн баримт бичгийг бэлтгэх;
- Зэвсэг, техник, тусгай хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн болон бие бүрэлдэхүүн, орон нутгийн хүм ам, хүрээлэн буй орчинд нөлөөлөх хор, аюул бүхий хүчин зүйлүүд, түүнчлэн орон нутгийн иргэд, байлдааны техникт байгаль, техникийн гаралтай хүчин зүйлийг тодорхойлох;
- Цэргийн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх болон бэлтгэн нийлүүлэхэд экологийн аюулгүй байдлыг хангах;
- Цэрэг, цэргийн обьектыг хүрээлэн буй орчинд аль болох тааламжгүй нөлөөлөл үзүүлэхгүйгээр зөв байрлуулах;
- Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг боловсруулахад санал бэлтгэх.

Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах дэд тогтолцоо нь тайван ба байлдааны цагт зорилго, агуулга шийдвэрлэх асуудал, хэрэгжүүлэх зарчим, арга, ашиглах хүч хэрэгслээрээ ялгаатай хоёр хэсэг арга хэмжээнээс бүрдэнэ.

Цэргийн албаны аюултай ба хортой хүчин зүйлийг илрүүлэх, урьдчилсан дүгнэлт гаргах, тэдгээрийг урьдчилан анхааруулах, аюулгүй болгох талаар шуурхай болон урт хугацааны цогцолбор арга хэмжээнээг хэрэгжүүлэх;

Цэргийн хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүний экологийн аюулгүй байдлыг шаардлагын түвшинд хангах;

Цэргийн албаны онцлогоос шалтгаалан өвчлөх, гэмтэл авахаас урьдчилан сэргийлэх;

Цэргийн обьект, цэргийн байрлалын районы экологийн аюулгүй байдал, онцгой тохиолдлын үеийн хамгаалагдсан байдалд аттестатчилал явуулах;

Аюулгүй байдлыг хангах хүч хэрэгсэлийг томилж, байнга бэлэн байлгах;

Бие бүрэлдэхүүний экологийн хамгаалалтыг хангах;

Ослын үед ажиллахад бие бүрэлдэхүүнийг бэлтгэх идэвхитэй арга хэрэгслийг бүрдүүлэх;

Цэргийн албаны аюулгүй байдлын талаархи асуудлаар бие бүрэлдэхүүнд эрх зүйн хүмүүжил, бэлтгэл олгох эдгээр арга хэмжээн байж болно.

Байлдааны ажиллагааны үеийн цэргийн албаны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ:

- Бие бүрэлдэхүүний байлдааны хохирлыг багасгах, байлдааны бус хохирлоос урьдчилан сэргийлэх;
- Байлдааны зэвсэг, техник, цэргийн обьектууд, анги, салбаруудын аюулгүй байдлыг хангах талаар цогцолбор арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх;
- Цэргийн албан хаагчдын эрхийг хамгаалах, зэвсэгт халдлагын үед олон улсын эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон бусад арга хэмжээнүүд байж болно.

Сүүлийн жилүүдэд дэлхийн ардчилсан олон нийт терроризмтай тэмцэх үйл явцдаа тэмцлийн ямар арга зам илүү үр дүнд хүрэх талаархи санал бодлын хүрээнд алан хядагчдын санхүүжилтийг зогсоох, олон улсын цагдаагийн хүчнийхний хамтарсан хүчээр тэмцэх, хилийн хяналтыг чангатгах, тагнуулын албадуудын хамтарсан ажиллагааг үр дүнтэй явуулснаар алан хядагчдын үйл ажиллагааг явуулах бололцоог нь тасалдуулах арга замыг юуны түрүүнд хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үзэж байгаагаас зарим судлаачид цэргийн хүчийг зайлшгүй ашиглахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсч байгааг онцгойлох боллоо. Иймд зэвсэгт халдлага болсон үед цэргийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсруулах хил хамгаалах байгууллагад цэргийн аюулгүй байдлыг хангах талаар сургалт, судалгааны ажил явуулж энэ чиглэлээр боловсон хүчин бэлтгэж ашиглах нь зүйтэй гэж үзэж байна. Хүн төвтэй, хүнлэг энэрэнгүй нийгэм байгуулахаар үндсэн хуулиндаа тунхагласан Монгол Улс иргэдийнхээ эрх, эрх чөлөө тэдний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, амгалан тайван байдлыг хангах элбэг хангалуун амьдрах нөхцөлийг бүрдүүлэх явдалыг үндэсний аюулгүй байдлын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж тэр тусмаа оршин тогтнохын аюулгүй байдлыг сахин хамгаалагч хилчин дайчдын аюулгүй байдлыг хамгаалах асуудал онцгой байр суурьтай юм.

Үндэсний аюулгүй байдлын гол цөм болсон хүний аюулгүй байдал нийгэмд чухал байр суурь эзэлж байгаа энэ үед хил хамгаалах байгууллага нийгмийн чиг хандлагыг дагаж цэргийн алба хаагч төвтэй цэргийн албаны харилцааг хөгжүүлэх хилийн анги, отрядыг хүний хөгжлийн төв болгон ажилуулж цэргийн алба хаагчдыг аливаа аюул заналаас хамгаалах явдал чухал учраас тэдний алба хаах аятай таатай нөхцөлийг бүрдүүлэх аюулгүй байдлыг нь бүх талаар хангах нь зүй ёсоор тавигдаж байна.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын*
*акаде.иийн 821 дүгээр дамжааны суралцагч,*
*хошууч Э.Майдар*

## ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

***Хураангуй.*** *Энэхүү илтгэлээр Монгол Улсад хил хамгаалах байгууллагын удирдлага зохион байгуулалтад дүн шинжилгээ хийж цаашид хил хамгаалах байгууллагын цэргийн мэргэжлийн удирдлагыг сайжруулахад өөрийн саналаа дэвшүүлсэн болно.*

***Түлхүүр*** *үг. Удирдлага, зохион байгуулалт, бүтэц, бүс нутаг, бүсчилсэн хил хамгаалалт, оператив удирдлага.*

Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд гарсан нэг чухал үйл явдал бол Монгол Улсын хил халдашгүй дархан байдлыг хангах зорилгоор хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч тээврийн хэрэгслэлийг нэвтрүүлэхэд, орон нутгийн байгууллагыг өргөн оролцуулах, хил зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагатай холбогдсон харилцааг зохицуулах чиг үүрэг бүхий Хилийн тухай хууль батлагдан мөрдөгдөж байгаа явдал юм.

Хилийн тусгай анги улсын хилийн дэглэм, хил орчмын дэглэмийн сахилгыг тухайн чиглэл, хэсэгт хэрэгжүүлэх үндсэн хүч учраас улсын хил дээр тайван цагт гарсан бүх асуудлыг хууль эрх зүйн дагуу үр ашигтай шийдвэрлэхээс гадна улсын хил дээр гарсан хилийн будлианыг цэрэг, дипломатын аргаас гадна цэргийн хүч хэрэглэж түүнийг ашигтайгаар шийдвэрлэх аргыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хариуцсан хэсэгт хангасан байх шаардлагатай.

Хил хамгаалах байгууллагын удирдах байгууллага нь Монгол Улсын хилийг хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хил хамгаалах, салбар нэгжүүдийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, удирдамж чиглэл үүрэг даалгавараар хангана.